

**Байгаль орчин, аялал жуулчлалын яамны аппаратын 2016 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор С.Энхзаяа

Утас: 261663 Цахим хаяг: enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Р.Гончигцэрэн

Утас: 261885 Цахим хаяг: gonchigtsetserenr@audit.gov.mn

Улаанбаатар хот

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.5	Дотоод хяналт	6
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.7	Шилэн дансны мэдээлэл	7
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.10	Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар	9
2.11	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	9
2.13	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	9
2.14	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	9
2.16	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
3.1	Төсвийг эдийн засгийн ангилалын дагуу бүртгэх	12
3.2	Зардлын гүйцэтгэлийг бодитой тооцох талаар	13
3.3	Төсвийг зориулалтын дагуу зарцуулах талаар	14
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	15
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	15
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	17
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	20
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	22
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	23

1 Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бара тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.20 № 3/250

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

БАЙГАЛЬ ОРЧИН НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРЫН БИЧГИЙН ДАРГА Ц.ЦЭНГЭЛ
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Татварын ерөнхий газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЭНХЗАЯА

УХА0122

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны аппаратын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг тус яамны удирдлагад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүүгийн дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримтласан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яамны аппаратын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны аппаратын 2016оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2016 оны 1 дүгээр сарын 30-наас 2016 оны 2 дугаар сарын 10-ны хооронд хийж, аудитын тайланг 2016 оны 2 дугаар сарын 16-нд эцэслэн баталгаажуулж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны удирдлагад танилцуулахаар төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Р.Гончигцэрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны аппаратын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлээ 2017 оны 1 дүгээр сарын 25-нд Үндэсний аудитын газарт хуулиар тогтоосон хугацаанд нь албан ёсоор ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны эрхэм зорилго нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн хандлагыг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглүүлж, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалж, ногоон хөгжлийг хангах үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад оршино.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4-т заасны дагуу Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагууд үйл ажиллагаандаа Байгаль орчныг хамгаалах тухай, Байгалийн ургамлын тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай, Ойн тухай, Амьтны тухай, Агаарын тухай, Усны тухай, Хог хаягдлын тухай зэрэг салбарын онцлог хууль эрхийн актуудыг мөрдөн ажиллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны аппаратын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгаж, баримтжуулсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төсвийн захирагч нь төсвийн шууд захирагчийн хувьд Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам, өөрийн байгууллагын баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн хүрээнд төсөв, санхүү бүртгэлийн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуураа болголоо.

Аудитаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамны аппаратын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын горим, сорил 3-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн материаллаг биш зөрчилтэй зарим асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайдын 2016 оны А/58 дугаар тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програм хангамж ашиглаж боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргажээ.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Санхүү, эдийн засгийн хэлтэс тус яамны аппаратын 2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар санхүүжүүлж, төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны аппаратын 2016 онд улсын төсвөөс 9,258.1 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 7,790.7 сая төгрөгийн санхүүжилт авч нийт гүйцэтгэл 84.15 хувьтай байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Байгаль орчин, аялал жуулчлалын яам Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Тухайлбал: Тус яам өөрийн цахим хуудсанд “Шилэн дансны мэдээлэл” нэртэй цэс үүсгэж, төсөв санхүүгийн ил тод байдал, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах ил тод байдал гэсэн багц мэдээллийг нээлттэй ил тодоор тухай бүр мэдээлж байна.

Мөн мэдээллийн ил тод байдал, тайлан зэрэг цэсүүдийг үндсэн үйл ажиллагаа болон төсөв, санхүүгийн шаардлагатай мэдээллийг ил тод мэдээлэх зорилготой ажиллуулж байна.

Аудитын явцад шилэн дансны аудитад шаардлагатай мэдээлэл, судалгааг тус яамнаас гаргуулж, Нийцлийн аудитын газарт шилжүүлсэн болно.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 18 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 7 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3-1-9/

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураагуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитын явцад хөндөгдсөн алдаа зөрчилтэй зарим асуудлыг дараах заалтад хураангуйлав.

Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа зөрчилтэй асуудал гараагүй бөгөөд материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт, Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх, Аялал жуулчлал хөтөлбөрүүдийн санхүүжилтийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж гэсэн зардлын ангилалд баталсан ба уг зардлын төсвөөс дараах урсгал зардлуудыг санхүүжүүлсэн байна.

Тухайлбал, Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт хөтөлбөрийн төсвөөс бичиг хэргийн материалын зардалд 1.8 сая төгрөг, томилолтоор явахад зарцуулсан шатахууны зардалд 3.6 сая төгрөг, Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрийн зардлаас 0.8 сая төгрөгийг антивирусын програм худалдан авахаар тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заасан “Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах” гэж заасныг, Сангийн сайдын 2015 оны “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 7-р тушаал, Сангийн сайдын 2014 оны 55-р тушаалаар баталсан эдийн засгийн ангилалыг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2. Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2015 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн Албан ажлаас чөлөөлөх Б-17 дугаар тушаалыг хүчингүй болгох Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүхийн тогтоол гарч, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн Доржийн Цэндэд 7.1 сая төгрөгийг нөхөн олгосон нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолын холбогдох заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

3. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарын бичгийн даргын 2016 оны А/258 дугаар тушаалаар “Цайны зам” хөтөлбөрийн дагуу яамны ажиллагсадын хүүхдүүдийг 2016 оны 7 дугаар сарын 19-нөөс 26-ны хооронд аялуулахдаа 20.0 сая төгрөгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөрийн төсвөөс гаргаж МАЖХолбоо төрийн бус байгууллагад шилжүүлсэн байна. Энэ нь МУЗГ-ын 2014 оны 147 тогтоолын 3.6-д “улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ялангуяа төсвийн нэмэлт орлого, хандив болон тусламжийн орлогоор гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх”, гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2.10 Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Энэхүү аудитаар залруулаагүй материаллаг хэмжээний алдаа гараагүй болно.

2.11 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал гараагүй.

2.12 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, зарим аудитын чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд зарим томоохон төсөл арга хэмжээ, түүний гүйцэтгэл, үр дүнд тавьж байгаа дотоод хяналтын үр нөлөөг үнэлж, нарийвчилсан горим сорил төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Тухайлбал тайлант хугацаанд Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрт 5,000.0 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын ангилалаар төсвийн хуваарьт баталж өгсөн байна. Томоохон төсөл арга хэмжээ, түүний гүйцэтгэл, үр дүн хэрэгжилтийн бодит байдлыг дүгнэх.

2.13 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны аппаратын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар асуудлын бүртгэлд нийт 3 асуудлаар 33.3 сая төгрөгийн алдаа, зөрчил бүртгэсэн бөгөөд үйл ажиллагааны зардалтай холбоотой 27.1 сая төгрөгийн зөрчилтэй асуудалд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Асуудлын бүртгэлийг баталгаажуулж, Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд бүртгэж, баримтжуулав.

2.14 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны аппаратын 2015 оны санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамрагдсан тул тусгайлсан зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.15 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны аппаратын 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 8,710.5 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 174.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.16 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Байгаль орчин, аялал жуулчлалын яамны аппаратын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны аппаратын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Байгаль орчин, ногоон хөгжилын яамны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Б.Нансалмаа, ахлах нягтлан бодогч О.Дуламсүрэн болон санхүү, бүртгэлийн бусад ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 Төсвийг эдийн засгийн ангилалын дагуу бүртгэх	Тэргүүлэх ач холбогдол №1
--	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт, Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх, Аялал жуулчлал хөтөлбөрүүдийн санхүүжилт бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж гэсэн зардлын ангилалд батлагдсан ба уг зардлын төсвөөс дараах урсгал зардлуудыг санхүүжүүлсэн байна.

Тухайлбал, Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт хөтөлбөрийн төсвөөс принтерийн хорны үнэ 1.8 сая төгрөгийг Эс Си Эл ХХК-д, томилолтоор явахад зарцуулсан шатахууны зардалд 3.6 сая төгрөгийг Магнай трейд ХХК-д, Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрийн зардлаас 0.8 сая төгрөгийг антивирусын програм худалдан авахаар Ньюсоник ХХК-д тус тус шилжүүлсэн байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, бодит байдлын тухай мэдэгдэл зөрчигдөх, төсвийн зарлагын гүйцэтгэл буруу илэрхийлэгдэх

ҮАГ-ын зөвлөмж

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заасан “Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах” гэж заасныг, Сангийн сайдын 2015 оны төсвийн ангилал шинэчлэн батлах тухай 7-р тушаал, Сангийн сайдын 2014 оны 55-р тушаалаар баталсан эдийн засгийн ангилалыг тус тус мөрдөж ажиллахыг тус яамны удирдлагад зөвлөмж өгөх.

Батлагдсан төсөвт зардлыг санхүүжүүлэхдээ тухайн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнг бүрэн тооцож, хянан баталгаажуулсны дараа нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтад үндэслэн зардлаар хүлээн зөвшөөрөх

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

3.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тооцох талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2015 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн Албан ажлаас чөлөөлөх Б-17 дугаар тушаалыг хүчингүй болгох Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүхийн тогтоол гарч, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн Доржийн Цэндэд 7.1 сая төгрөгийг нөхөн олгосон нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", УИХ-ын 2016 оны 47 тогтоолын холбогдох заалтыг тус тус нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, бодит байдлын тухай мэдэгдэл зөрчигдөх, төсвийн зарлагын гүйцэтгэл буруу илэрхийлэгдэх

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", УИХ-ын 2016 оны 47 төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх тогтоол тус тус мөрдөж ажиллах. Алдаа зөрчилийг давтан гаргахгүй байх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

3.3 Төсвийг зориулалтын дагуу ЗАРЦУУЛАХ ТАЛААР	Тэргүүлэх ач холбогдол №3
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарын бичгийн даргын 2016 оны А/258 дугаар тушаалаар “Цайны зам” хөтөлбөрийн дагуу яамны ажиллагсадын хүүхдүүдийг 2016 оны 7 дугаар сарын 19-26-ны өдрийн хооронд аялуулахдаа 20.0 сая төгрөгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөрийн төсвөөс гаргаж МАЖХолбоо төрийн бус байгууллагад шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, УИХ-ын 2016 оны 47 тогтоолтой тус тус нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, бодит байдлын тухай мэдэгдэл зөрчигдөх, төсвийн зарлагын гүйцэтгэл буруу илэрхийлэгдэх

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, УИХ-ын 2016 оны 47 тогтоол, Сангийн сайдын 2015 оны 7-р тушаалыг тус тус мөрдөж ажиллах.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,097,920,017.01</u>	<u>6,101,579,290.24</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	
33	АВЛАГА	357,785,460.41	322,221,218.63
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,800,000.00	4,800,000.00
335	Бусад авлага	352,985,460.41	317,421,218.63
3351	Байгууллагаас авах авлага	352,985,460.41	317,148,280.55
3352	Хувь хүмүүсээс авах авлага		272,938.08
34	УРЬДЧИЛГАА	5,572,218,000.00	5,584,932,324.00
34600	Урьдчилж гарсан зардал	5,572,218,000.00	5,584,932,324.00
35	БАРАА МАТЕРИАЛ	167,916,556.60	194,425,747.61
354	Хангамжийн материал	167,916,556.60	194,425,747.61
35410	Бичиг хэргийн материал	16,043,018.99	10,362,210.00
35420	Аж ахуйн материал	89,874,847.40	116,454,797.40
35430	Сэлбэг хэрэгсэл	2,322,817.00	2,322,817.00
35440	Түлш, шатах тослох материал	7,894,900.00	13,504,950.00
35470	Бусад хангамжийн материал	51,780,973.21	51,780,973.21
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,366,875,198.38</u>	<u>2,776,006,071.22</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,366,875,198.38	2,776,006,071.22
391	Газар		
392	Биет хөрөнгө	3,238,312,470.30	2,696,972,100.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,349,381,240.00	1,349,381,240.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(607,809,739.15)	(665,464,741.87)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	369,772,600.00	368,894,600.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(213,527,162.25)	(265,611,162.25)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,704,052,719.66	1,727,536,969.02
39206	Хуримтлагдсан элэгдэл	(849,708,064.60)	(1,257,896,900.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	796,878,318.12	824,215,758.12
39208	Хуримтлагдсан элэгдэл	(605,380,061.82)	(671,294,466.68)

39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,174,000,000.00	1,174,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	129,016,941.00	129,016,941.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,364,320.66)	(15,806,135.72)
393	Биет бус хөрөнгө	128,562,728.08	79,033,970.52
39301	Програм хангамж	22,348,250.00	22,748,250.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(19,270,671.92)	(20,747,909.42)
39303	Бусад биет бус хөрөнгө	242,511,400.00	242,511,400.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(117,026,250.00)	(165,477,770.06)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>9,464,795,215.39</u>	<u>8,877,585,361.46</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,336,359,801.36</u>	<u>198,653,709.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,336,359,801.36	198,653,709.00
413	Өглөг	2,336,359,801.36	198,653,709.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	11,498,860.36	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	54,094,238.00	39,242,271.00
4136	Бусад өглөг	2,270,766,703.00	159,411,438.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,270,766,703.00	159,411,438.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>7,128,435,414.03</u>	<u>8,678,931,652.46</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	7,128,435,414.03	8,678,931,652.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,954,229,779.25	2,954,229,779.25
51101	Өмч: - төрийн	2,954,229,779.25	2,954,229,779.25
512	Хуримтлагдсан үр дүн	4,118,767,312.61	5,669,263,551.04
51210	Өмнөх үеийн үр дүн	4,118,767,312.61	4,263,267,312.61
51220	Тайлант үеийн үр дүн		1,405,996,238.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	55,438,322.17	55,438,322.17
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>9,464,795,215.39</u>	<u>8,877,585,361.46</u>

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,738,594,218.90	10,122,416,104.53
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	497,182,830.87	45,342,998.53
120	Нийтлэг татварын бус орлого	489,842,112.87	43,589,062.17
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	487,884,914.87	43,589,062.17
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	473,320,735.62	7,625,497.17
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,652,373.25	2,030,565.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,911,806.00	33,933,000.00
120009	Бусад орлого	1,957,198.00	
121	Хөрөнгийн орлого	7,340,718.00	1,753,936.36
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	7,340,718.00	2,153,936.36
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,241,411,388.03	10,077,073,106.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,807,575,917.00	7,775,852,091.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,807,575,917.00	7,775,852,091.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	433,835,471.03	2,301,221,015.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	433,705,471.03	1,801,483,296.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		168,775,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		330,962,719.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	130,000.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,624,269,747.40	8,714,405,874.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,621,389,747.40	8,714,405,874.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,156,322,195.56	8,081,070,767.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,452,807,291.35	1,635,008,394.32
210101	Үндсэн цалин	1,415,799,065.65	1,418,636,146.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,277,520.70	125,151,609.00
210104	Урамшуулал	435,000.00	
210105	Гэрээт ажлын хөлс	3,295,705.00	91,220,639.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	203,864,048.65	185,638,538.38

210201	Тэтгэврийн даатгал	175,669,790.65	120,466,200.30
210202	Тэтгэмжийн даатгал	3,589,472.00	8,175,207.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,110,918.00	16,336,264.97
210204	Ажилгүйдлийн даатгал	3,498,773.00	8,145,357.32
210205	Эрүүл мэндийн даатгал	13,995,095.00	32,515,508.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,724,380.00	73,082,300.00
210301	Гэрэл, цахилгаан	14,011,763.00	19,121,600.00
210302	Түлш, халаалт	29,934,000.00	38,787,700.00
210303	Цэвэр, бохир ус	10,778,617.00	15,173,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	136,753,987.14	120,193,170.99
210401	Бичиг хэрэг	20,116,220.00	49,997,526.26
210402	Тээвэр, шатахуун	7,413,340.00	34,965,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,502,324.80	28,775,422.00
210404	Ном, хэвлэл	52,118,650.00	5,585,681.73
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	26,809,892.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,793,560.34	869,491.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,113,280.00	2,164,399.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,933,280.00	
210602	Тавилга	18,900.00	-
210604	Урсгал засвар	7,161,100.00	2,164,399.00
2107	Томилолт, зочны зардал	29,058,580.00	8,370,700.00
210701	Гадаад албан томилолт	5,500,000.00	
210702	Дотоод албан томилолт	12,998,970.00	6,553,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	10,559,610.00	1,817,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,635,174,984.54	5,123,813,950.21
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,623,104,853.74	5,115,973,156.21
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	1,340,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,260,864.80	2,263,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	765,400.00	1,000,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	99,140.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,297,000.00	1,169,120.00
210807	Газрын төлбөр	1,796,866.00	1,969,534.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,634,825,643.88	932,799,314.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,346,307,523.83	255,964,903.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,781,000.00	32,107,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	277,737,120.05	644,726,911.42
212	ТАТААС	22,503,611.12	-
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	22,503,611.12	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	442,563,940.72	633,335,106.68
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	69,674,526.84	160,178,355.14

213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	69,674,526.84	160,178,355.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	247,371,489.06	334,680,775.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	186,509,205.00	72,076,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,158,412.00	142,968,056.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,703,872.06	119,636,319.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	125,517,924.82	138,475,976.54
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	125,517,924.82	138,475,976.54
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,880,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	2,880,000.00	-
223001	Бусад хөрөнгө	2,880,000.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	114,324,471.50	1,408,010,230.53
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	50,828,756.29	2,013,992.10
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	50,828,756.29	2,013,992.10
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(50,828,756.29)	(2,013,992.10)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	63,495,715.21	1,405,996,238.43

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	8,888,994,852.28	10,093,471,833.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,081,418,935.28	16,398,727.70
120	Нийтлэг татварын бус орлого	1,081,418,935.28	16,398,727.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,081,418,935.28	16,398,727.70
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,072,766,562.03	14,368,162.70
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,652,373.25	2,030,565.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,807,575,917.00	10,077,073,106.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,807,575,917.00	7,775,852,091.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,807,575,917.00	7,775,852,091.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,301,221,015.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,801,483,296.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		499,737,719.00
2	НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	8,888,994,852.28	10,052,967,683.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,888,994,852.28	10,052,967,683.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,371,749,801.36	9,412,573,742.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,460,978,503.00	1,606,907,915.81
210101	Үндсэн цалин	1,286,444,900.00	1,378,690,009.81
210102	Нэмэгдэл		14,273,170.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	128,042,900.00	123,156,336.00
210105	Гэрээт ажлын хөлс	46,490,703.00	90,788,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	173,598,700.00	179,595,800.00
210201	Тэтгэврийн даатгал	173,598,700.00	179,595,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,110,580.00	73,082,300.00
210301	Гэрэл, цахилгаан	15,380,370.00	19,121,600.00
210302	Түлш, халаалт	29,934,000.00	38,787,700.00
210303	Цэвэр, бохир ус	10,796,210.00	15,173,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	61,561,258.51	63,303,500.00
210401	Бичиг хэрэг	16,281,760.00	15,670,400.00
210402	Тээвэр, шатахуун	13,402,340.00	15,226,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	26,140,160.00	27,658,900.00
210404	Ном, хэвлэл	816,050.00	2,800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,920,948.51	1,947,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,670,200.00	6,431,388.00
210604	Урсгал засвар	10,670,200.00	6,431,388.00
2107	Томилолт, зочны зардал	29,096,080.00	10,199,800.00
210701	Гадаад албан томилолт	5,500,000.00	
210702	Дотоод албан томилолт	12,998,970.00	10,199,800.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	10,597,110.00	

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,277,571,533.10	7,184,560,860.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,262,095,268.30	7,167,613,066.17
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	1,340,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,260,864.80	2,263,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	765,400.00	1,000,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	99,140.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,000,000.00	9,746,620.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,500,000.00	2,499,034.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,302,162,946.75	288,492,179.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,287,611,946.75	254,425,679.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,551,000.00	34,066,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	517,245,050.92	640,393,940.68
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	119,960,586.10	160,178,355.14
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	119,960,586.10	160,178,355.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	271,766,540.00	341,739,609.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	194,672,581.00	72,076,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,158,412.00	142,968,056.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	43,935,547.00	126,695,153.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	125,517,924.82	138,475,976.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	125,517,924.82	138,475,976.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	40,504,150.04
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	40,504,150.04
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	40,504,150.04
2200	Дотоод эх үүсвэрээр	-	40,504,150.04
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		40,504,150.04
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(40,504,150.04)

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,954,229,779.25	0.00	0.00	2,954,229,779.25
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,954,229,779.25	0.00	0.00	2,954,229,779.25
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,954,229,779.25	0.00	0.00	7,128,435,414.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			144,550,000.00	144,500,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,954,229,779.25	55,438,322.17	4,263,267,312.61	7,272,935,414.03
D08	Тайлант үеийн үр дүн			1,405,996,238.43	1,405,996,238.43
D09	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,954,229,779.25	55,438,322.17	5,669,263,551.04	8,678,931,652.46

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/ төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,217,116,300.00	7,816,228,290.25	9,258,072,500.00	7,792,250,818.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,217,116,300.00	7,816,228,290.25	9,258,072,500.00	7,792,250,818.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,795,869,000.00	7,321,860,206.10	8,075,370,300.00	7,288,681,789.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,461,226,100.00	1,460,978,503.00	1,632,689,500.00	1,606,907,915.81
210101	Үндсэн цалин	1,286,444,900.00	1,286,444,900.00	1,399,996,000.00	1,378,690,009.81
210102	Нэмэгдэл			13,862,500.00	14,273,170.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	128,042,600.00	128,042,900.00	128,042,600.00	123,156,336.00
210105	Гэрээт ажлын хөлс	46,738,600.00	46,490,703.00	90,788,400.00	90,788,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	173,598,700.00	173,598,700.00	179,595,600.00	179,595,800.00
210201	Тэтгэврийн даатгал	110,471,900.00	110,471,900.00	114,287,900.00	114,287,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,625,400.00	12,625,400.00	13,061,600.00	13,061,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,781,800.00	15,781,800.00	16,326,900.00	16,326,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,156,200.00	3,156,200.00	3,265,400.00	3,265,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	31,563,400.00	31,563,400.00	32,653,800.00	32,653,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,027,600.00	56,110,580.00	73,082,300.00	73,082,300.00
210301	Гэрэл, цахилгаан	16,627,500.00	15,380,370.00	19,121,600.00	19,121,600.00
210302	Түлш, халаалт	33,728,400.00	29,934,000.00	38,787,700.00	38,787,700.00
210303	Цэвэр, бохир ус	11,671,700.00	10,796,210.00	15,173,000.00	15,173,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	63,405,000.00	58,880,310.00	60,488,900.00	60,503,500.00
210401	Бичиг хэрэг	16,937,500.00	16,281,760.00	15,655,800.00	15,670,400.00
210402	Тээвэр, шатахуун	14,418,100.00	13,402,340.00	15,226,900.00	15,226,900.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	29,085,400.00	26,140,160.00	27,658,900.00	27,658,900.00
210404	Ном, хэвлэл	724,000.00	816,050.00	1,947,300.00	1,947,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,240,000.00	2,240,000.00		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,625,000.00	10,670,200.00	11,093,400.00	7,131,388.00
210604	Урсгал засвар	10,625,000.00	10,670,200.00	11,093,400.00	7,131,388.00
2107	Томилолт, зочны зардал	36,936,100.00	29,096,080.00	10,199,800.00	10,199,800.00
210701	Гадаад албан томилолт	5,500,000.00	5,500,000.00		
210702	Дотоод албан томилолт	19,000,100.00	12,998,970.00	10,199,800.00	10,199,800.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	12,436,000.00	10,597,110.00		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,558,866,600.00	5,277,571,533.10	5,831,720,100.00	5,077,156,406.21
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,542,688,100.00	5,262,095,268.30	5,813,857,100.00	5,059,955,612.21
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	850,000.00	2,000,000.00	1,340,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,263,000.00	2,260,864.80	2,263,000.00	2,263,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	765,500.00	765,400.00	1,000,000.00	1,000,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	100,000.00	100,000.00	99,140.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,700,000.00	9,000,000.00	10,000,000.00	9,999,620.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,500,000.00	2,500,000.00	2,500,000.00	2,499,034.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	429,183,900.00	254,954,300.00	276,500,700.00	274,104,679.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	414,183,900.00	240,403,300.00	244,996,700.00	240,038,179.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,000,000.00	14,551,000.00	31,504,000.00	34,066,500.00
211	ХҮҮ	-	108,896,505.05	-	128,346,218.54

2111	Төвлүүлэх шилжүүлэг	-	108,896,505.05	-	128,346,218.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	421,247,300.00	385,471,579.10	1,182,702,200.00	375,222,811.14
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	120,000,000.00	119,960,586.10	160,957,500.00	160,178,355.14
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	120,000,000.00	119,960,586.10	160,957,500.00	160,178,355.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	301,247,300.00	265,510,993.00	1,021,744,700.00	215,044,456.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	301,247,300.00	194,672,581.00	72,076,400.00	72,076,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		33,158,412.00	949,668,300.00	142,968,056.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		37,680,000.00		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,425,648,902.66	7,816,228,290.25	9,258,072,500.00	7,792,250,818.70
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,425,648,902.66	7,807,575,917.00	9,258,072,500.00	7,775,852,091.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	7,425,648,902.66	7,807,575,917.00	9,258,072,500.00	7,775,852,091.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	8,652,373.25	-	16,398,727.70
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		8,652,373.25		2,030,565.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих				14,368,162.70
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага			1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	110.00	110.00	121.00	121.00
620001	Удирдах ажилтан	18.00	18.00	18.00	18.00
620002	Гүйцэтгэх ажилтан	80.00	80.00	91.00	91.00
620004	Гэрээт ажилтан	12.00	12.00	12.00	12.00